

ШИВЭЭГОВЬ СУМЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

/2021.02.25-2021.03.25/

УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Сумын 22-р зөрлөг дээр 1 пост ажиллуулж 2-р сарын 24-өөс 3-р сарын 24-ний хооронд давхардсан тоогоор сумаас гарсан 3400 тээврийн хэрэгсэл, 9200 зорчигч, сум руу орсон 3600 тээврийн хэрэгсэл 10800 зорчигч, дамжин өнгөрсөн 93 тээврийн хэрэгсэл 240 зорчигч хөдөлгөөнд оролцсон байна.

Шивээговь суманд 2-р сарын 24-өөс 3-р сарын 24-ний хооронд Улаанбаатар хотоос 141 иргэн ирж гэр бүлийн 126 иргэний хамт гэрийн тусгаарлалтанд 7 хоног тусгаарлагдаж тусгаарлалтаас гарсан 194 иргэнийг түргэвчилсэн шинжилгээнд хамруулсан байна.

Сумын шуурхай штабаас Улаанбаатар хот болон өөр аймаг орон нутаг руу зорчих зөвшөөрлийг зөвшөөрөгдсөн 4 шалтгаанаар 44 иргэнд олгоод байна.

Сумын Засаг даргын 2021 оны 03-р сарын 01-ний өдрийн А/27 дугаар Захирамжаар “Цэргийн бүртгэл явуулах тухай” ажлын хэсэг томилогдон Цэргийн шинэчилсэн тоо бүртгэлийн ажлыг 2021 оны 03-р сарын 01-нээс 03-р сарын 12-ны хооронд зохион байгуулж 40 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

Шороон шуурганы улмаас малчдаар тойрох ажлыг 2021 оны 03 сарын 17, 18-ны өдрүүдэд зохион байгуулж 2 хэсэг болон малчин 61 айл өрхөөр нийт 680 км газар явахад сумын малчин өрхийн 90 гаруй хувь нь малаа уруудуулсан байна. Мөн 3 айлын гэр нурж хана, унь, тооно хугарсан дахин барих боломжгүй болсон байна. Мөн хашаа хорооны хэсэг шатсан 1 айл байна. Малчдын хаваржилт хүнд, өвс тэжээлийн нөөцгүй, малын тарга хүч муудсан, хээл хаясан, зоо нуруугаар нь шороо чихсэн учир улам ядарч байна гэсэн өгүүлэмжтэй байна. Иймд гамшигт өртсөн айл өрх, эд хөрөнгийн судалгааг иргэдийн мэдээллийг үндэслэн гаргаж аймгийн онцгой комисст танилцуулсанаар өнөөдрийн байдлаар 2 өрхөд гэр, 1980 боодол өвсийг үнэ төлбөргүй олгохоор шийдвэрлээд байна.

ДЭД БҮТЭЦ, ГАЗРЫН ТАЛААР


Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраас 2018, 2019 онд газрын төлбөрийн өр төлүүлэх талаар албан бичиг ирүүлсэний дагуу 63 газар эзэмшигч

иргэн, аж ахуйн нэгж байгууллагад газрын төлбөрийн нэхэмжлэх тарааж, 39 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад утсаар болон амаар мэдэгдэж, сумын shiveegovi.gs.gov.mn, Шивээ нэгдсэн зарын сайтаар газрын төлбөрийн мэдээ мэдээллийг хүргэж ажилласнаар 2021 оны 03-р сарын 22 –ны өдрийн байдлаар 41 иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас 3 063 515 төгрөгийг орон нутгийн орлогот төвлөрүүлээд байна.



Сумын Засаг даргын 2020 оны А/40 дүгээр захирамжаар “Газар зүйн нэрийн салбар зөвлөл байгуулах тухай” ажлын хэсэг томилогдон сумын 1, 2-р багт нэр өгөх ажлыг зохион байгуулж, саналын хуудсаар нийт 168 иргэнээс, “Google forms” программыг ашиглаж нийт 38 иргэнээс цахим санал ирүүлсэн байна. Цар тахлын үед багийн иргэдийн нийтийн хурлыг хуралдуулах боломжгүй байгаа тул багийн

Иргэдийн Нийтийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэн 1 дүгээр багт Мөнх-өсөх, 2 дугаар Багт Эрдэнэтолгой, Бэхт, Нэрт зэрэг нэрүүдийг санал болгон ирүүлсэнийг газар зүйн нэрийн салбар зөвлөлийн ажлын хэсгээр хэлэлцүүлэн нэрсийг тодруулж ИТХ-д хүргүүлсэнээр сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 74 дугаар тогтоолоор 1 дүгээр багийг **БЭХТ**, 2 дугаар багийг **НЭРТ** гэж нэрлэхээр аймгийн Засаг даргад уламжлаад байна. Тус 2 нэр нь сумын баруун урд байрлалтай ундрагатай 2 булагийн нэрээр нэрлэсэн юм. Нийт санал өгсөн иргэдийн 70 орчим хувь нь тус 2 нэрийн саналыг гаргасан байна.



ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ

Засаг даргын Тамгын газарт дотоод удирдлагын ERP цахим системийг нэвтрүүлж хүний нөөцийн мэдээллүүдийг бүртгээд байна.

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

3-Р СУРГУУЛЬ :

Улсын онцгой комиссын даргын 2021 оны 02 сарын 22-ны өдрийн 18 дугаар тушаалаар батлагдсан “Коронавируст халдвар (Ковид-19)-аас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам” болон Боловсрол, шинжлэх ухааны сайдын А/58 дугаар тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалтын үйл ажиллагааг танхимаар зохион байгуулах түр журам”-ын дагуу хоцрогдлыг арилгах танхимын сургалтыг анги бүр 2 дэд бүлгээр, нэг ээлжиндээ 13-аас 18 сурагчийг хуваарилан халдвар хамгаалал, эрүүл ахуйн дэглэмийг баримтлан ажиллаж байна.



Үдийн цайг анги бүрт хүргэх, хүргэсэн ажилтан анги, танхимд орохгүй байх



Хүүхэд нэг бүрийн халууныг хэмжих, гарыг ариутгах дадалд хэвшүүлэх



Хичээл эхлэх, тарах цагийг зөрүүтэй тогтоох, зай барин зогсож ангидаа орох



Анги, танхимдаа зай барин сууж, өдөр бүр 50 мин-аар зөвхөн монгол хэл, математикийн хоцрогдлыг нөхөх 2 цагийн хичээл ордог.



Хоёр хичээлийн дундуур өдөр бүр 15 минут “Эрүүл мэндийн зөвлөмж”-ийн цагийг төлөвлөж, үр бүтээлтэй ашиглаж байна.

Дотуур байрны 28 хүүхдийг шинжилгээнд хамруулан байранд хүлээн авсан.

Сургуулийн дотуур байр, гал тогоо, ангиудад дотоод хяналтаар 2 удаа явж шалгалт хийж цар тахлаас урьдчилан сэргийлэх дэглэмийг мөрдүүлэх талаар зөвөлгөө өгч ажилласан.



Сургуулийн бага анги, дунд ангид халуун хэмжигч, гар ариутгагч байршуулж багш ажилчдын халууныг өдөр бүр хэмжин хяналт тавин ажиллаж байна. Мөн 1-12 ангиуд бүгд COVID-19 эсрэг самбар хийж байрлуулсан.



Аймаг бүрд агуулгын хоцрогдлыг арилгахад дэмжлэг үзүүлэх зорилгоор зохион байгуулагдсан мэргэжлийн буюу судлагдахууны багийн ахлагч, гишүүдийн шалгуурт нийцүүлэн боловсруулсан оношилгооны сэдвээр 1-5-р ангийн хүүхэд нэг бүрийн теле хичээлийн болон зайн сургалтын агуулгыг эзэмшсэн байдалд оношилгоо хийж нэгтгэв.

Бага боловсролын монгол хэл, математикийн хичээлийн агуулгын судалгааг 1-р хагас жилийн төлөвлөлтийн дагуу нягтлахад:

Хичээл	Танхимаар судалсан	ТВ-ээр судалсан	Цахим хичээлээр судалсан	Нийт хувь	Орхигдсон агуулгын хувь	Хэвлэмэл материал хүргэсэн
	хувь					
Монгол хэл	55.1	14.4	8.7	78.2	21.8	2153 ш
Математик	50.9	22.2	9.8	82.9	19.2	1494 ш

Цаашид оношилгооны үр дүн болон агуулгын судалгааны нэгтгэлд үндэслэж 1-р хагас жилийн болон 2 дугаар сарын зайн сургалтыг үеийн хоцрогдлыг арилгах агуулгын төлөвлөлтийг дахин сайжруулах шаардлагтай болсон тул багш нар секцээрээ хамтран боловсруулалтаа хийж, батлуулан ажиллаж байна.

СОЁЛЫН ТАЛААР

Монгол цэргийн бахархалын өдөр, Монгол улсад орчин цагийн зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны түүхт 100 жилийн ойн баярыг тохиолдуулан “Зочны булан” баярын арга хэмжээг зохион байгуулж дээрх үйл ажиллагаанд Шивээговь сумын Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч Монгол Улсын Соёлын Тэргүүний ажилтан, Боржигин түрлэг уртын дууны холбооны тэргүүн, Аймгийн Ахлах цолчин засуул О.Алтанхүү, Монгол улсын Тэргүүний Ардын авьяастан Гочоогийн Батсайхан нар уригдан оролцлоо. Уг арга хэмжээг цахимаар хүргэсэн бөгөөд 4.4 мянган хүн үзэж, 202 удаа шэйр хийгдсэн байна.

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Зочны булан” баярын арга хэмжээг цахимаар зохион байгууллаа. Зочны буланд Шивээговь сумын Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч, Монгол Улсын Соёлын Тэргүүний Ажилтан Доржийн Нараа, Монгол Улсын Тэргүүний Ардын авьяастан Жамъянгийн Сүнжидмаа нар оролцлоо. Дээрх арга хэмжээг цахимаар хүргэсэн төдийгүй 523 хүн үзэж 15 удаа шэйр хийгдсэн байна.

Соёлын төвийн 15 жилийн ойг тохиолдуулан 15 жилийн ойн хүндэт тэмдэгийг хийлгэж “Зочны булан” арга хэмжээнд оролцсон МУСТА О. Алтанхүү, Д. Нараа, МУТАА Г. Батсайхан, Ж. Сүнжидмаа нарт гардуулсан.



Байгууллагын хөгжмийн багшийн “**Морин хуур**” хөгжмийн дугуйлан өдөр бүр үдээс өмнө, үдээс хойш гэсэн цагийн хувиараар халдвар хамгааллын дэглэмийг баримтлан тогтмол хичээллэж байна. Дугуйланд нийт 10 суралцагч хамрагдаж байна.



Байгууллагын бүжгийн багшийн санаачлагаар “Бүжгээр жингээ хасая” хөгжимт хөдөлгөөний сургалтанд сумын 10 гаруй эмэгтэйчүүд хамрагдаж байна. Дээрх сургалт өглөө орой гэсэн 2 халдвар хамгааллын дэглэмийг баримтлан 1 цагийн хугацаанд хичээллэж байна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ

Эрүүл мэндийн төвд 18 өвчтөн хэвтэж үүнээс 4-н хүүхэд хэвтэн эмчлүүлж байна. Эмнэлгийн үйлчилгээ нь:

- Амбулаторийн үзлэг – 505 томуу-42
- Урьдчилан сэргийлэх – 0
- PCR шинжилгээ-194-үүнээс түргэвчилсэн -22
- Дуудлага-146

Эрүүл мэндийн төвийн магадлан итгэмжлэлийн өөрийн үнэлгээний тайлан, Байгууллагын чанарын хөгжлийн хөтөлбөрийн тайлан болон магадлан итгэмжлэлд шаардагдах баримт бичгүүдийг бэлтгэн аймгийн эрүүл мэндийн газарт хүргүүлсэн.

НИЙГМИЙН ХАЛАМЖ

Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын зорилтод бүлгийн иргэдэд үйлчилэх хүнсний дэлгүүрийг сонгон шалгаруулах тендерт “Оюу шивээ арвижих” ХХК-тай шалгарч гэрээ байгуулан 3-р сарын 1224000 төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг олгоод байна.

Хиймэл шүд хийлгэсэн 2 ахмад настанд 260000 төгрөгийн хөнгөлөлт, бүрэн хараагүй 6 иргэнд 120000 төгрөгийн харилцаа холбооны зарлыг олгосон.

НИЙГМИЙН БОДЛОГО

Насан туршийн боловсрол олгох Энтерпренершипийн сургалтыг ерөнхий боловсролын сургуулийн 8-12 ангийн 24, 24 сурагчтай 2 бүлэг , насанд хүрэгчдийн

20 сурагчтай 1 бүлэгтэйгээр байгуулж 3 сарын 16-ны өдөр нээлтээ хийж сургалтын үйл ажиллагаагаа эхлүүллээ.



Биеийн тамир спортын улсын хорооноос орон даяар зохион байгуулж буй эрүүл мэндийн цахим гүйлт 2021 аянд сумын 7 байгууллагын 8 удирдах ажилчдыг хамруулж, байгууллагын дарга бүр ажилтан, албан хаагчдаа хамруулаад байна.



УЛСЫН БҮРТГЭЛ

Иргэний бүртгэлийн үйлчилгээг 48 иргэнд үзүүлсэн ба үүнээс шинэчилсэн бүртгэлд 9 иргэнг бүртгэж баримтыг аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний бүртгэлийн тасагт хүлээлгэн өгч экспорт хийгээд байна.

3-р сард газраа анх удаа өмчилж авч байгаа 8 иргэний материалыг хүлээн авч газар өмчлөлийн гэрчилгээг олгоод байна. Нийт 19 иргэн газар өмчлөлийн гэрчилгээг аймаг орохгүйгээр сумаасаа аваад байна.

Иргэдээс 25 өргөдөл хүлээн авсныг хугацаанд нь шийдвэрлэсэн.

Иргэний гэр бүл байдлын статистик мэдээ тайлан болон Иргэний бүртгэлийн чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, үнэт цаасны тайлан, үнэт цаасны орлогын тайлан зэргийг гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.

ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ 2021 ОНЫ 03 САРЫН МЭДЭЭ
Шивээговь

	м/д	Бүгд	Үүнээс:					
			Хот			Хөдөө		
			Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Төрсөн хүүхэд	1	17				17	11	6
Төрсөн эх	2	16				16		16
Бүртгүүлсэн гэр бүл	3	2				2	2	2
Нас баралт	4	5				5	4	1
Цуцалсан гэр бүл	5	2				2	2	2
Үрчлэгдсэн хүүхэд	6	1				1	-	1
Аймаг, нийслэлээс шилжин ирсэн	7	69				69	34	35
Аймаг, нийслэл рүү шилжин явсан	8	-				-	-	-

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ШИВЭЭГОВЬ СУМЫН ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНЭЭС ОРСОН ОРЛОГО**

2021.03.24.

д/д	Үйлчилгээний нэр төрөл	2021 оны 03-р сар					Бүгд	Тайлбар
		Үйлчилгээний хураамж 300200022101 тоот дансанд		Бүгд	Тэмдэгтийн хураамж 300300123138 тоот дансанд			
		Нэг бүрийн үнэ	Тоо		Нэг бүрийн үнэ	Тоо		
1	Нийслэлээс шилжин ирсэн	5000	2	10000	1000	2	2000	
2	Өөр аймгаас шилжин ирсэн	2500	7	17500	1000	7	7000	
3	Лавлагаа	1000	2	2000				
Дүн				29500	9000			
д/д	Үйлчилгээний нэр төрөл	Үйлчилгээний хураамж 300200022130 тоот дансанд		Бүгд	Тэмдэгтийн хураамж 300300123138 тоот дансанд		Бүгд	Тайлбар
		Нэг бүрийн үнэ	Тоо		Нэг бүрийн үнэ	Тоо		
4	Иргэний үнэмлэх	15000	9	120000	3300	9	29700	
Дүн		135000			26400			
Нийлбэр дүн		164500			38700			
Нийт орлогын дүн		203200						

ХӨДӨӨ АЖ АХУЙ, МАЛ ЭМНЭЛЭГИЙН ТАСАГ

Төлийн мэдээг 7 хоног тутам гаргаж Аймгийн ХХААГ-т хүргүүлж байна. 03-р сарын 24-ний байдлаар ингэ-6, ямаа-743, хонь- 824, үнээ-17, нийт 1590 мал төллөж, 1598 төл бойжиж, 3 тугал, 328 хурга, 98 ишиг нийт 429 төл хорогдсон байна. Том малын зүй бус хорогдол 2844 байна.

Байгалийн гамшигт үзэгдэл болсонтой холбогдуулан Шивээговь суманд гадны аймаг сумдын малчид дамжин өнгөрөх зорилгоор отор нүүдэлээр их дамжин өнгөрч байна. 3-р сарын 24-ний байдлаар Шивээговь суманд 12 өрхийн 6828 толгой мал отроор ирсэн байна.

Сумаас гадны аймаг сумдад отор нүүдэл хийж буй 13 малчин 6719 толгой мал отроор явж байна.

Шивээговь сумын хүнсний нөөцийн судалгааг нийт 10 дэлгүүр, 1 махны лангуу, 1 усны үйлдвэрээс тус тус авч аймгийн ХХААГ-т хүргүүлэн ажиллаж байна. 3-р сарын 24-ний өдрийн байдлаар суманд мах-3,6 тн, гурил-6,7 тн, гурилан бүтээгдэхүүн-0,4 тн, төрөл бүрийн будаа-2,5 тн, сүү-0,5 тн, өндөг-0,1 тн, ургамалын тос-0,8 тн, төмс-2,5 тн, хүнсний ногоо-0,9 тн, элсэн чихэр-0,5 тн, давс-0,5 тн, савласан ус-2,6 тн-ын нөөцтэй байна.

БАЙГАЛЬ ОРЧИН

Сумын Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн А/29 дугаар захирамжаар “Сэг зэм устгах” ажлын хэсгийг 8 хүний бүрэлдэхүүнтэй томилон сэг зэм устгалын ажлыг “Хийморь Алтай групп” мал эмнэлгийн нэгж хамтран 2021 оны 3 сарын 04, 05, 06-ны өдрүүдэд 2 техник хэрэгсэлээр 2 дугаар багийн нутгаар 640 километр явж, адуу-33, үхэр-56, хонь-1498, ямаа-953, зээр-54, нохой-1, нэхий 30, үнэг-5 нийт 2630 мал, амьтаны сэг зэмийг 6 цэгт ариутгал халдваргүйжүүлэлт хийн булаж устгасан.



Бүх нийтийн их цэвэрлэгээг 03 дугаар сарын 11,12-ны өдрүүдэд 2 удаа зохион байгуулаж, сумын төвийн ногоон байгууламжийн хуваарьт талбай, гудамж, байр орон сууц, төв хогийн цэгийн нийт 7 га талбайн 27 тн хог хаягдлыг цэвэрлэн ажиллаа.

Мөн Шивээ-Овоо хувьцаат компани болон “Сдент” ХХК-ийн техник хэрэгсэлүүдийг ашиглан зүүн гэр байрны баруун урд талд 1 га талбайн туурь болон

хуримтлагдсан хог хаягдал, төв хогийн цэгийн 1,2 га талбайн хур хог хаягдал, 22-р зөрлөгийн хогийн цэгийн 500мкв газруудыг түрж тэгшилсэн. Цэвэрлэгээнд давхардсан тоогоор 22 аж ахуй нэгж албан байгууллагын 226 ажилтан албан хаагчид 34 иргэн хамрагдсан.

Өмнө нь



Дараа нь

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Шивээговь сумын 2021 оны “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Цагдаагийн



эргүүлийн автомашин худалдан авах” ажлын нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийг харьцуулалтын аргаар



зохион байгуулж “Очирт хөрс” ХХК-ийн сонгон шалгаруулж гэрээ байгуулах мэдэгдэлийг 2021 оны 03 сарын 18-нд хүргүүлээд байна.

Суманд “Замын тэмдэг тэмдэглэгээг сайжруулах” ажлын шууд худалдан авалтын сонгон шалгаруулалтад “Их-Эффект” ХХК шалгарч 4250000 төгрөгийн гэрээг байгуулаад байна.

МЭДЭЭ ГАРГАСАН:

ХЭЗХМЭРГЭЖИЛТЭН

О.БОЛОРМАА

ХЯНАСАН:

ЗДТГ-ЫН ДАРГА

Д.ОТГОНЖАРГАЛ

